



2025 оны хагас жилийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

*Studlagil Canyon Iceland | Basalt Canyon in East Iceland

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ****Оноосон нэр:**

Монгол Базальт ХК

Байгуулагдсан огноо:

2007

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Үйл ажиллагааны**чиглэл:**

Чулуун хөвөнгийн
үйлдвэр,
үйлдвэрийн хүчин чадал:

Цагт 2.5 тн**Хаяг:**

Монгол улс, Улаанбаатар
хот, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Фламинго тауэр, 403
тоот

Утас, и-мэйл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn

**УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ****ТУЗ-ийн дарга:**

Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

85

**ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ****Хувьцааны
симбол код:**

MSE:MBW / 544

**МХБиржид
бүртгэгдсэн:**

2018.04.05

**Нийт гаргасан
хувьцаа:**

56,417,000 ширхэг





АЛСЫН ХАРАА

Галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тотвортой нийгмийг цогцлооно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг тав тухтай, барилга хийцийн эрсдэлгүй, байгальд хамгийн ойр байлгаж, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгоно.

ТОВЧ ТҮҮХ



2009

Чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулж, анхны бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлсэн.



2019

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж, хүчин чадлаа 1.5 дахин нэмэгдүүлсэн. Базальт чулуун хөвөн хөрсний судалгааг эхлүүлсэн



2022

Базальт фибер арматур үйлдвэрлэх технологийг нэвтрүүлж, Монголын анхны базальт фибер арматурын үйлдвэр байгуулсан.



2024

Пассив базальт панелт хийц технологи, үйлвэрийг байгуулсан



2007

Монгол Базальт ХК-ийн ТУЗ-ийн дарга, үүсгэн байгуулагч Л.Ариунболд Чулуун хөвөнгийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан.



2013

Дулааны шугам хоолойн дулаалга үйлдвэрлэх СТУ дулаалгын технологийг нэвтрүүлж, Термобазальт үйлдвэрийг байгуулсан.



2021

Чулуун хөвөнд суурилсан инновацийн Базальт арматур, Базальт сэндвич, Грөвүүл 3 төсөл амжилттай хэрэгжүүлсэн.



2023

Базальт кассет сэндвич хавтан үйлдвэрлэх технологийг боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛТ ХК

ТАНЫ ДУЛААЛГЫН ТӨГС ШИЙДЭЛ



НАСЖИЛТ
100 ЖИЛ



ЭКО
БҮТЭЭГДХҮҮН



ДУУ ЧИМЭЭ
ТУСГААРЛАНА



ХАЛУУН
ХҮЙТЭН
ТУСГААРЛАНА



ГАЛД
ШАТДАГҮЙ



БАТ БЭХ
ТОГТВОРТОЙ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн зарчим-ыг баримтлан, олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг тэнцвэртэй хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэцтэйгээр ажиллаж байна.

Цаашид компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг улам сайжруулах, түүний хэвшил, тогтвортой байдлыг бий болгох, компанийн засаглалын соёлыг гүнзгийрүүлэх зорилтын хүрээнд тогтвортой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

ТУЗ нь 2025 оны эхний хагас жилд танхим цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 4 удаа ирц бүрэн хуралдаж, 13 тогтоол, шийдвэр гаргасан.

ТУЗ-ИЙН ХОРООД

- 1. Нэр дэвшүүлэх хороо
- 2. Аудитын хороо
- 3. Цалин урамшууллын хороо
- 4. Эрсдлийн удирдлагын хороо

1

ТУЗ-ийн бүрэлдэхүүн



Л.Ариунболд



Б.Шаравсамбуу



Хан Гю Бунг



П.Сайнбилэг



Г.Ганзориг



А.Энхгэрэл



Ш.Энхтөр



П.Нямдорж



Ч.Зоригтбаатар

2

Бодлогын баримт бичиг

Шинээр боловсруулж баталсан бодлогын баримт бичиг:


Баримт бичгийн нэр
Бизнесийн ёс зүйн дүрэм
Эрсдлийн удирдлагын хорооны журам
Эрсдлийн удирдлагын бодлого
Залгамж халааны бодлого
Цалин урамшууллын бодлого
Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого

Компанийн засаглалын кодексын үнэлгээ:


98.6%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ ХАНШ



ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК




Тайлант хугацаанд Монгол Базальт ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааны дээд ханш 208.43 төгрөг, доод ханш 161.03 төгрөг байсан бол 2025 оны эхний хагас жилийн хаалтын ханш 179.9 төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд сард дунджаар 130,435 ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд нийт 782,615 ширхэг хувьцаа 149.9 сая төгрөгийн үнийн дүнтэйгээр хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсан үзүүлэлттэй байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь компанийн үнэт цаасны хөрвөх чадвар, хөрөнгө оруулагчдын итгэл, зах зээлийн идэвхжил тогтвортой байгааг харуулж байна.

2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4 дүгээр сарын 30-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор, нэгж хувьцаанд 2.42 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, нийт 136,529,140 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар баталж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК (ҮЦТХТ ХХК)-ээр дамжуулан 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд амжилттай тараан байршуулсан болно.

1

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



2

Нөлөө бүхий хувьцаа эзэшигчид

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%

ХҮНИЙ НӨӨЦ


Компанийн нийт ажилтны 80 хувь нь дээд боловсролтой, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг төгссөн бөгөөд 70 хувь нь 3-аас дээш жил тасралтгүй ажилласан нь хүний нөөцийн ур чадвар, туршлага, тогтвортой байдлыг илтгэж байна.

Мөн хүний нөөцийн эргэцийн дундаж хувь 2.6% байгаа нь манай байгууллага ажилтнуудаа хадгалан тогтвортой ажиллуулах, ажлын байрны сэтгэл ханамжийг хангах чиглэлд үр дүнтэй бодлого хэрэгжүүлж байгааг харуулж байна.



Гал унтраах практик сургалт - 2025 он


Хүйсийн харьцаа



Хүний нөөцийн харьцуулалт



Цалингийн сангийн харьцуулалт /сая төгрөг/



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2025 оны эхний хагас жилийн байдлаар чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэр нийт 468 тонн чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргасан байна.

Мөн шугам хоолойн дулаалгын цехийн хүрээнд нийт 2716 метр шугам болон яндан хоолой дулаалга үйлдвэрлэсэн.

Үйлдвэрийн хэмжээнд их бүтээн байгуулалт, засвар шинэчлэлийн ажлууд эрчимтэй өрнөж, тоног төхөөрөмжийн туршилт, тохируулгын ажил бүрэн хийгдсэн. Энэ нь үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа, бүтээгдэхүүний чанарын хяналтыг дээшлүүлэх чухал суурь болсон.

Цаашид бид:

- Хавтан бүтээгдэхүүний чанарыг тасралтгүй сайжруулж, технологийн горимыг өндөр түвшинд мөрдүүлэн ажиллах;
- Хүн хүчний нөөцийг бэлтгэх, сургах, чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг чанд мөрдөх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн сайжруулах зорилт тавин ажиллаж байна.




САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2025 оны хагас жилд компанийн борлуулалтын орлого 3.388 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй (2024 он – 5.017 тэрбум төгрөг) харьцуулахад 32.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Борлуулалтын орлого буурахад дараах гол хүчин зүйлс нөлөөлсөн болно:

- Барилгын салбарын эрэлт буурсан. Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төрийн худалдан авалтын хэмжээ буурч, барилгын салбарын эргэлт саарсан нь дулаан тусгаарлагч бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлсөн.
- Үйлдвэрлэлийн урсгал зардал нэмэгдсэн. Түүхий эд, тээвэр, эрчим хүчний зардал өссөнөөр бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэн хэдий ч зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд борлуулалтын үнийг төдийлөн нэмэгдүүлэх боломжгүй байсан нь ашгийн хэмжээнд болон борлуулалтын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн.

БОРЛУУЛАЛТ / САЯ.ТӨГРӨГ




2025 оны эхний хагас жилд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласны үр дүнд 79213 мянга орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 65.6%-ийг базальт лайт, 16%-ийг базальт хауз, 15%-ийг базальт вэнт фасад, 3.5%-ийг базальт техно стандарт марк тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлт нь хувь хэрэглэгчидийн худалдан авалт идвэхитэй байгааг илэрхийлж байна.

Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%
2023	1,184,757,000.00	96.1%	21₮	10.2%
2024	136,529,140.00		2.42₮	

Ногдол ашгийн өсөлт /₮/



Сургалт

2025 оны 1,2 сар - байшин сууцаа дахин дулаалах замаар утааг бууруулах талаар мэдээлэл хүргэх зорилго бүхий “Утааг дулаалж ялна” сэдэвт сургалтуудыг СХД-ийн 4, 5, 7, 10, 26, 33 хороодууд зохион байгуулсан ба нийт 571 иргэнийг хамруулав.

2025 оны 3 сар - Барилга угсралтын компани, бригадууд, төсөл хэрэгжүүлэгчид болон салбарын мэрэгжилтэн нарын дунд термопассив хаус бүтэц элемент угсрах зааварчилгаа болон технологийн зөвшилцөх уулзалтыг зохион байгуулав.

2025 оны 4 сар- Дархан хотын иргэдэд пассив панел хийц технологи танилцуулах нээлттэй өдөрлөг зохион байгуулав.



Үзэсгэлэн арга хэмжээ

- 2025 оны 4 сар :**
- Барилга экспо 2025 /зохион байгуулагч-Барилга.мн/
 - Тогтвортой хөгжил ногоон ирээдүй /зохион байгуулагч-Төрийн банк ХК/
 - Чингэлтэй дүүргийн Амины орон сууцны мэдээллийн төвийн нээлтийн арга хэмжээ /зохион байгуулагч-БХБОСЯ/
 - Оюуны өмчийн өдөрлөг /Гаалийн ерөнхий газар/
- 2025 оны 5 сар:**
- Дулаан байшин өдөрлөг /зохион байгуулагч-БХБОСЯ/
 - Дархан барилга экспо 2025



Шүршдэг чулуун хөвөнгийн стандарт

MNS GB/T 26746:2025 Дулаан тусгаарлалтын шүршдэг эрдэс хөвөн

MNS JC/T 903:2025 Утаслаг ширхэглэл эрдэс хөвөн стандартуудыг орчуулж стандарчлалын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулав.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Монгол Базальт ХК нь НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ” (UN Global Compact) болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд нэгдэн орох үүрэг, амлалтыг хүлээн ажиллаж байгаа бөгөөд бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг компанийн удирдлагын тогтолцоо болон өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараатайгаар нэвтрүүлж байна.

Энэхүү алхам нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин, авлигын эсрэг үйл ажиллагааны 10 зарчмыг хэрэгжүүлэх компанийн эрмэлзлийг илэрхийлэхийн сацуу, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг төлөвшүүлэхэд чиглэсэн стратегийн чухал шийдвэр юм.

Тус компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 12-т нийцэж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна.

Тогтвортой хөгжил, байгаль орчны хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй санаачилгууд Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэлээр Монгол Улсад тэргүүлэгч “Монгол Базальт” ХК нь байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагаа явуулах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлд бодитой алхмууд хийсээр байна.



Компанийн эрхэм зорилгын хүрээнд бид:

- Галын аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлт, дотоод орчны тав тухыг хангасан тогтвортой бүтээгдэхүүн, шийдлүүдийг санал болгож, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж байна.
- Тогтвортой хөгжил болон ногоон үйлдвэрлэлийн зарчмыг дэмжих үүднээс дахин боловсруулалт, дугуй эдийн засгийн чиглэлээр хэд хэдэн санаачилга хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал, чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийн явцад үүсэх хаягдлыг дахин боловсруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, түүгээр дамжуулан байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, нөөцийг үр ашигтай ашиглах зорилго тавин ажиллаж байна. Эдгээр санаачилгууд нь зөвхөн компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх төдийгүй Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн чухал үйл ажиллагаа болж байна.

**SOUND
ABSORBENT**



**FIRE
RESISTANT**



**WATER
REPELLENT**





SDG 17:

үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАМЫН ЗУРАГ



SDG 13: 🎯

Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга, байгууламж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ



SDG 7: 🎯

Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж эрчим хүчний хэмнэлттэй болсон



SDG 6: 🎯

Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт саарал усыг хэрэглээнд оруулсан



SDG 13: 🎯

Үйлдвэрийн гарах хоолойн уудын филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн




SDG 8: 🎯

Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан



SDG 9: 🎯

Бат бөх, гал тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх



SDG 8: 🎯

Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих



SDG 13: >>>

Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламж үйлдвэрлэлийг идэвхижүүлэх



SDG 11: >>>

Оролгод нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих



SDG 7: >>>

Эрчим хүчний хэмнэлттэй барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



SDG 6: >>>

Тариалалтын усны хэрэглээг багасгах



SDG 2: >>>

Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох



SDG 12: 🎯

Хог хаягдалгүй үр ашигтай үйлдвэрлэл



SDG 3: >>>

Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх



Тогтвортой хөгжлийн зорилт



Бүтээгдэхүүний хэмжүүр

GROWOOL
SUSTAINABLE GROWING



SDG 12: **NET ZERO**

BASALTCycling Roadmap

BASALTCycle дахин боловсруулах хөтөлбөр



SDG 13:
Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламжийн үйлдвэрлэлийг дэмжих



SDG 11:
Хямд үнэтэй орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих



SDG 7:
Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



SDG 3:
Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх



Түүхий эд /базальт, шохойн чулуу/

Basaltwool дулаан тусгаарлагч хавтангийн үйлдвэрлэл


Барилга




Монгол Базальт ХК нь өндөр чанарын, ногоон барилгын дулаалгын материалуудыг Европын Холбооны галын A1 зэрэглэлийг хангаж нийлүүлж байна. Хариуцлагатай барилгын салбарыг Инновациар дэмжинэ.



Тээвэрлэлт



Барилга нураалт



Дахин боловсруулсан түүхий эд



Үйлдвэрлэлийн хог хаягдал

Барилгын хаягдал чулуун хөвөн, үйлчлүүлэгчдээс хаягдсан материалыг тээвэрлэх


НОГООН ТӨСӨЛ GROWOOL



Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.

Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт апыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээллийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна. 2023 онд төслийг өргөжүүлэн 4 улирлын гидропоник хүлэмж байгуулах ажлыг эхлүүлсэн ба 2024 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.



ТОГТВОРТОЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.

2 өлсгөлөнг
зогсоох




6 БАТАЛГААТ УНДНЫ УС
АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖААР
ХАНГАХ



15 ХУУРАЙ ГАЗРЫН
ЭКО СИСТЕМИЙГ
ХАМГААЛАХ





***Studlagil Canyon Iceland | Basalt Canyon in East Iceland**

Social Media

 **Mongol Basalt JSC**

 **Mongol_Basalt**

 **www.basaltwool.mn**

Contact

 **monbasalt@rockwool.mn**

 **+976 75114444, 77006768**

 **БГД, 29-р хороо,
үйлдвэрийн бүс 1-35,
Монгол Базальт ХК-ийн
байр**